

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ
12 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	Дараа сарын 02-ны дотор	2024 оны 12-р сарын байдлаар манай байгууллага 277,006.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 237,082.5 мянган төгрөгийг зарцуулж, 39,923.5 мянган төгрөг тайлант хугацаанд зарцуулагдаагүй байна.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 14 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Ниймгийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	11-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Хуулийн хэрэгжилт хангагдана	12 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баянтал, Сүмбэр, Шивээговь сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 1-11 сарын мэдээллийг үнэн зөв оруулсан эсэхэд нэг бүрчилсэн хяналт шалгалт хийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 50 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Тухайн сард аймгийн Орон нутаг хөгжүүлэх сан, Боржиго чуулга, Ус ду ОНӨААТҮГазар, Баянтал ХХСан 4 байгууллага мэдээллээ хоцроожээ. Тайлант хугацаанд хуулийн хэрэгжилт 98,9 хувьтай. Энэ нь өмнөх сараас 1.6%-иар өсчээ.
3	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	12 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 4 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудас https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 22 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.

4	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	12 сар	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 1 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.
				Баянтал сумын ЗДТГ-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавив. Зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай хэрэгжсэн байна.
				Сүмбэр сумын 1 дүгээр сургуульд хийсэн дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд гүйцэтгэлийн хяналт хийв. Зөвлөмжийн хэрэгжилт 87 хувьтай байна.
				Байгууллагын албан хаагчдад хувь хүний хөгжлийн 1 өдрийн багц сургалтыг зохион байгуулав. Сургалтанд 4 албан хаагч хамрагдав.
5	“УС-ДУ” ОНӨААТҮГазрын 2023-2024.09 сар хүртлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	12 сар	“УС-ДУ” ОНӨААТҮГазрын 2023-2024.09 сар хүртлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Аудитын явц 50 хувьтай үргэлжилж байна.
6	Орон нутгийн өмчийн газарт Дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	12 сар	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар Орон нутгийн өмчийн газарт дотоод аудит хийв. Дотоод аудитаар байгууллагын засаглал, дотоод хяналт, эрсдэлийн тогтолцооны түвшин 71.4 хувь нь 1-р түвшин буюу ЭХЛЭЛИЙН, 7.2 хувь нь 2-р түвшин буюу ДАВТАМЖТАЙ, 21.4 хувь нь 3-р түвшин буюу ТОМЬЁОЛСОН үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 9 зөрчил бүгд нөлөө ихтэй буюу “Хангалтгүй” дүгнэлтийг өгч байна. Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн байгаа нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон дотоод хяналтын үйл явц тогтоогүй, байгууллага 2024 онд тусдаа статустай байгууллага болсонтой холбоотойгоор үйл ажиллагаа тогтмолжоогүй байгаатай холбоотой байна. Дотоод аудитаар илэрсэн 9 асуудлын хүрээнд 22 зөвлөмжийг арилгуулахаар хугацаатай зөвлөмжийг өгөв. Барилгын асуудал, хүний нөөц, тогтвортой ажиллах мэргэжлийн боловсон хүчин олдохгүй, байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

7	Ус-Ду ОНӨҮГ-ын 2021-2023 оны баримтанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	12 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар удирдамжаар тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 50%тай явж байна.
8	Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	12 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 07 дугаар удирдамжаар тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 95 хувьтай явж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Нягтлан бодогч:



Б.Аззаяа